



Date 15 December 2016

(Mongools)

Эрхэмсэг ноён/ хатагтай,

Та Нидерландад цагаачаар орогнох хүсэлтэндээ татгалзсан хариу авсан. Тиймээс та цаашид юу болох талаар аль болох хурдан хугацаанд мэдэхийг хүсч байгаа гэж би ойлгож байна. Та энэхүү захианд цаашид юу болох талаар унших болно.

Орогнох байргүй болох

Та Нидерландад үлдэх эрх авч чадаагүй. Тиймээс та Нидерланд улсыг орхиж явах шаардлагатай. Үүнээс үүдээд та цагаачийн байранд байх эрхгүй болно. Мөн та татгалзсан шийдвэрийнхээ эсрэг шүүхэд давж заалдаж байх үедээ ч цагаачийн газарт байрлах эрхгүй болохоор энэ шийдвэрээ авсан даруйдаа цагаачийн газраасаа явах шаардлагатай. Та Европын Холбоонд хамрагдсан аль нэг улс оронд урьд нь бүртгэлтэй байсан энэ тохиолдолд таныг тэр улсруу тань явуулах хүртэл цагаачийн төвд байрлуулдаг.

Нидерландыг орхин гарах

Нидерландаас гарах хариуцлагыг та өөрөө хүлээдэг. Буцааж Явуулах Байгууллага таныг нутагруугаа явахад тань тусламж үзүүлж чадна.

Нутаг дэвсгэртээ орохыг хориглох

Танд Нидерландаас гарах тэр мөчид наашаагаа орж ирэх эрхийг хоёр жилийн хугацаагаар хасдаг. Энэ нь та хоёр жилийн хугацаанд Нидерланд болон Европийн Холбооны Улсад орж ирэх эрхгүй болж байна гэсэн үг юм. Хэрэв та энэ хугацаанд Европийн нутаг дэвсгэрт орж ирсэн тохиолдолд танд дээд тал нь 4100 евроны торгууль оноодог. Та хэрэвзээ торгуулиа төлж чадахгүй бол таныг шоронд суулгадаг.

Гадаадын иргэдийг саатуулан хорих

Бид таныг эндээс бие даан явахыг таны өөрийн үүрэг гэж үздэг ба хэрэв та өөрөө эндээс явах ямар нэг арга хэмжээ аваагүй тохиолдолд таныг гадаадын иргэдийг саатуулан хорих шоронд хийдэг. Тэгээд таныг хорихоос нутагруу тань буцааж явуулдаг.

Европийн Холбооны аль нэг улсад бүртгэлтэй байх

Та урд нь Европийн Холбоонд хамрагдсан аль нэг оронд бүртгэлтэй байсан уу? Тэгвэл тэр улс таны цагаачийн асуудлыг хариуцах үүрэгтэй байдаг. Тиймээс Нидерланд таныг тэр улсруу тань аль болох хурдан хугацаанд буцааж явуулдаг.

Амгалан тайван байдлыг алдагдуулах

Хармсалтай нь зарим нэг тохиолдолд (харалсан) цагаачид цагаачийн газарт болон цагаачийн газрын ойр орчинд бусдын амгалан тайван байдлыг алдагдуулдаг. Ямарваа нэг хүн ийм байдал гаргавал бид тэр даруйдаа арга хэмжээ авдаг ба энэ нь таныг цагаачийн газарт орж ирэхийг хориглох, мөн таныг гадаадын иргэдийг хориход суулгах эсвэл танд шоронд хорих ял оноох хүртэл арга хэмжээнүүдийг авч болдог.

Би энэхүү захиагаар танд хангалттай мэдээлэл өгсөн гэж найдаж байна.

Хүндэтгэсэн,

Докторант К. Х. Д. М.

Хууль Зүй ба Аюулгүй Байдлыг хамгаалах яамны төрийн нарийн бичгийн дарга

Information Department

Date

15 December 2016

Our reference

Та нэмэлт мэдээллийг доорх хаягруу ороод уншиж болно:

www.ind.nl

www.coa.nl

www.dienstterugkeerenvertrek.nl

www.iom-nederland.nl